

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04-р сарын 22 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 22-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, “Шинэ монгол хаад групп” ХХК-ийн байр, 2-р давхарын хурлын танхимд хуралдав.

**Хуралд оролцсон:**

1. Т.Төгс-Од /Хурлын дарга/
2. Lee Jeoung Ho /”Эм Ди Кэй Ай” ХХК-г/ төлөөлж – Хувьцаа эзэмшигч
3. Г.Сугирсүрэн /Тооллогын комиссын дарга/
4. Ж.Билэгдэмбэрэл /ТУЗ-н Аудитын хороон дарга/
5. Д.Булгамаа /Нарийн бичгийн дарга/

**Хурлын ирц:**

Тооллогын комиссын дарга Г.Сугирсүрэнгийн танилцуулснаар:

“Жидакс” ХК-ийн нийт гаргасан 13,735,752 ширхэг хувьцаа байгаагаас 13,735,752 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2026 оны 3-р сарын 31-ний өдрөөр нийт 167 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 13,560,394 ширхэг хувьцаатай “Эм Ди Кэй Ай” ХХК буюу 98,72 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дүгээр заасны дагуу **хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.** Оролцсон хувьцаа эзэмшигч:

| №    | Хувьцаа эзэмшигчийн овог нэр                                    | Хувьцааны тоо ширхэг | Эзэмшил хувь |
|------|-----------------------------------------------------------------|----------------------|--------------|
| 1    | “Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж<br>Гүйцэтгэх захирал Lee Jeoung Ho | 13,560,394           | 98.72%       |
| Нийт |                                                                 | 13,560,394           | 98.72%       |

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03-р сарын 17-ны өдрийн 26/02 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

**Хэлэлцэх асуудал 1: 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах,**

Т.Төгс-Од: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудитын байгууллагын баталгаажсан тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах,

Хурлын дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороон дарга Ж.Билэгдэмбэрэл жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийн тухай мэдээлэл өгнө.

Ж.Билэгдэмбэрэл: Хуралд хүрэлцэн ирсэн болон цахимаар оролцож буй та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй “Шонхор үнэлгээ аудит” ХХК аудитын байгууллагатай хамтран ажиллан, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон бусад холбогдох хууль дүрэм журамд нийцүүлэн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээг авсан болно. Хувьцаа эзэмшигч та бүхэнд урьдчилан аудитын тайланг танилцуулсан, асууж тодруулах зүйл байвал нээлттэй асууж болно.

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Аудитын үйлчилгээг зөвшөөрөлтэй баталгаат байгууллагаар хийлгэсэн байна, нэмж хэлэх санал үгүй болно. Цаашид компани төлөвлөгөө боловсруулан, ашиг орлогоо нэмэгдүүлэн ажиллах болно.

Хурлын дарга: 1-р асуудлыг батлах уу?

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Нэгдүгээр асуудлыг батлах саналтай байна.

**Шийдвэр 1:** 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудитын байгууллагын баталгаажсан тайланг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

**Хэлэлцэх асуудал 2: 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хувиарлах эсэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 26/01 тоот тогтоолыг танилцуулах,**

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 26/01 тоот тогтоолыг уншиж танилцуулья. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2-р сарын 14-ний өдрийн 26/01 тоот тогтоолд 2025 оны санхүүгийн үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг баталсан.

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Тогтоолыг уншиж танилцсан, компани ашиг орлогоо нэмэгдүүлэх тал дээр цаашид анхаарч ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэртэй санал нэг байна.

**Хэлэлцэх асуудал 3: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох,**

Т.Төгс-Од: 2025 оны санхүүгийн тайлангаас харахад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин, урамшуулал олгох боломжгүй гэж үзэж байна. Энэ асуудалд анхаарлаа хандуулахыг гүйцэтгэх удирдлагад танилцуулан ажиллана.

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж ашиг орлого болох үед цалин, урамшуулал олгохыг зорин, дэмжин ажиллана.

Хурлын дарга: 3-р асуудлыг батлах уу?

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Хэлэлцэж байгаа асуудлыг батлах саналтай байна

**Шийдвэр 3:** Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

**Хэлэлцэх асуудал 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,**

Т.Төгс-Од: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд дараах нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгох саналыг оруулж байна.

Хараат бус гишүүд: - Лхагвасүрэн овогтой Ганчимэг  
- Бямбаа овогтой Ариунболд  
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл

Ердийн гишүүд: - Lee овогтой Jeoung Ho  
- Төмөрбаатар овогтой Төгс-Од  
- Бямбаа овогтой Нарантуяа  
- Дашням овогтой Гантуул  
- Дорлигжав овогтой Болормаа  
- Гаравсэнгэ овогтой Хонгорзул

Lee Jeoung Ho: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан томилохыг зөвшөөрч санал нэг байна.

Хурлын дарга: 4-р асуудлыг батлах уу?

Хувьцаа эзэмшигч Lee Jeoung Ho: Батлах саналтай байна

**Шийдвэр 4:** Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах гишүүдийг улируулан СОНГОСУГАЙ.

Ердийн гишүүд:


- Lee овогтой Jeoung Ho
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Дорлигжав овогтой Болормаа
- Гаравсэнгэ овогтой Хонгорзул

Хараат бус гишүүд:


- Лхагвасүрэн овогтой Ганчимэг
- Бямбаа овогтой Ариунболд
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл нарыг сонгосугай.

Хурлын дарга Т.Төгс-Од хуралд оролцогсдод талархал илэрхийлж 14:00 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

 Д.БУЛГАМАА

Танилцсан Хурлын дарга:

 Т.ТӨГС-ОД